



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 622

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа,
үнийг шинэчлэн тогтоож балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 5,346,600.00 (таван сая гурван зуун дөчин зургаан мянга зургаан зуун) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал Б.Нарантуяа, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх, шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123006697
32-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны дүгээр сарын 30 -ны өдрийн
басгал дугаар тогтоолын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ АШИГЛАХ ХУГАЦАА,
ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн (ашиглалтад) орсон огноо	Нийт гүйлт (км)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жил)	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)
1	Сервир компьютер /Dell Power Edge R710/	2012-08-20	412,422	5,346,600.00	5	5,346,600.00
НИЙТ ДҮН						
				5,346,600.00 (таван сая гурван зуун дөчин зургаан мянга зургаан зуун)		5,346,600.00 (таван сая гурван зуун дөчин зургаан мянга зургаан зуун)